

**ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛУУДЫН ЗӨВЛӨЛ (ACI)-ИЙН БОЛОН АЗИ,  
НОМХОН ДАЛАЙ, ОЙРХ ДОРНОДЫН БҮСИЙН ЭЭЛЖИТ АССАМБЛЕЙ  
(WAGA-2024)-Д ОРОЛЦСОН ТУХАЙ ТАЙЛАН**

2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/260 дугаар тушаалын дагуу тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ч.Одгэрэл, Иргэний нисэхийн үндэсний төвийн Хүний нөөцийн удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Нэргүй нар Саудын Арабын Хаант Улсын Эр-Риад хотод 2024 оны 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (ACI)-ийн дэлхийн болон Ази, номхон далай, Ойрх Дорнодын бүсийн ээлжит Ассамблей (WAGA-2024) бага хуралд оролцсон.

Саудын Арабын Хаант Улсын "King Khalid Олон улсын нисэх буудал (KKIA)-ын оператор компани болох Riyadh Airports Компани зохион байгуулсан. Тус ассамблейд дэлхийн 70 гаруй орны олон улсын иргэний нисэхийн дээд түвшний удирдлагууд, бодлого боловсруулагчид, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэгч бизнесийн түншүүд, бодлогын шинжээчид, нисэх буудлын удирдлагууд зэрэг 700 гаруй зочил төлөөлөгчид оролцон нисэх буудлын зорчигчдын хэрэгцээ шаардлагаг анхаарал хандуулж, олон улсын болон бүс нутгийн нислэгийн сүлжлийн тогтвортой байдлыг хангахад агаарын тээврийн салбар далай нэр хүндтэй илтгэлт насаар удирдуулсан сонирхолтой илтгэл, хэлэлцүүлэг, семинаруудыг зохион байгуулсан.

Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (ACI)-ийн болон Ази, номхон далай, Ойрх Дорнодын бүсийн ээлжит Ассамблей (WAGA 2024) дээр агаарын тээврийн салбарын хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, стратеги, дэвшлийг танилцуулах дараах үндсэн үйл ажиллагаанууд явагдсан. Үүнд:

- Нисэх буудлын менежмент, үйл ажиллагаанд инновацыг бий болгож буй хамгийн сүүлийн үеийн технологи, үйлчилгээ, шийдлүүдийг харуулсан үзэсгэлэн
- Агаарын тээврийн салбарынхан болон сонирхогч талуудын хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх хуралдаанууд.
- Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (ACI) Ази, номхон далай, Ойрх Дорнодын бүсийн байнгын хорооны хуралдаанууд
- Нисэх буудлын өрсөлдөх чадвар, жижиглэнгийн худалдаа, хоол хүнс, ундаа, агаарын тээврийн либералчлал, аялал жуулчлал, агаарын тээврийн тогтвортой байдал, эко шатахуун-SAF, нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт, агаарын карго тээврийн боломж, зорчигчдын үйл явц болон бусад сэдвээр C-suite хэлэлцүүлэг зэрэг болно.

Олон улсын нисэх буудлын зөвлөл (ACI)-ийн Ази Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн 47 орны 624 нисэх буудлыг төлөөлдөг тус бүсийн эрэнхийн ассамблей дээр тус бүс нутгийн тогтвортой хөгжлийн зорилтуудад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд бүс нутгийн нислэгийн сүлжлийн сэргээж, хөгжүүлэх талаар хийгдсэн ажлуудыг талаарх ACI-ийн Ази-

илтгэлдээ: "Ази Номхон далайн бүс нутагт нислэгийн сүлжил аажмаар сэргэж, Ойрх Дорнодод тогтвортой өсөлттэй байгаа зэрэг дүр зураг харагдаж байгаа бөгөөд шаардлагатай шинэчлэлийг хэрэгжүүлэх, ялангуяа ирээдүйн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нисэх буудлын шинэ дэд бүтцийг цаг тухайд нь барьж байгуулах, зах

зээлийг цаашид либералчлах, визний бодлогыг зөөлрүүлэхэд тохиромжтой цаг болсон. Эдгээр хүчин зүйлүүд нь агаарын тээврийн хэрэглэгчдэд илүү боломжийн үнээр сонголт хийх, үр ашигтай ажиллах гол түлхүүр болно" хэмээн онцолсон. Мөн тэрээр 2024 оны хэтийн төлөв 2024 оны 1-р улирлын индексээс харахад нисэх буудлуудын нислэгийн сүлжил 2023 оны мөн үетэй харьцуулахад дунджаар 59%-аар өссөн байна. Ази, номхон далай болон ойрх дорнодын нисэх буудлуудын 2024 оны 3-р улиралд зорчигч тээвэрлэлт 2023 оны мөн үетэй харьцуулахад дунджаар 10%-аар нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд 2024 онд зорчигч тээвэрлэлтийн хамгийн өндөр өсөлт нь Хятад Улс руу болон Хятадаас Улсаас шууд нислэг хийх хандлагатай байна. Мөн Ойрх Дорнодын Эр-Рияд, Абу Даби, Дубай зэрэг хотууд анхаарлын төвд байх болно хэмээн мэдэгдсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ч.Одгэрэл 2024 оны 5 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Олон улсын нисэх буудлын зөвлөл (ACI)-ийн Ази Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн Аюулгүй ажиллагааны байнгын хорооны хуралд оролцсон. Мөн тэрээр 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан Олон улсын нисэх буудлын зөвлөл (ACI)-ийн Ази Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн 1 дэх удаагийн ерөнхий ассамблейн хуралдаанд оролцсон.

Тэрээр тус хуралдааны дараа ACI-ийн Ази Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн ерөнхий захирал ноён Стефано Барончитай уулзсан. Тус уулзалтын үеэр ноён Стефано Барончи энэ оны 7 сарын 5 дугаар сард Монгол улсад ирж манай орон нутгийн нисэх буудлууд болон шинэ нисэх буудлын үйл ажиллагаатай танилцан манай улсын иргэний нисэхийн нэг нисэх буудалд Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (ACI)-ийн хэрэгжүүлдэг Airport Excellence Program (APEX) хөтөлбөрийг хэрэгжүүлж, дэлхийн хэмжээнд нисэх буудлын үйл ажиллагаа, зохицуулалтын нийцэл, нисэхийн стандартыг оновчтой болгохын тулд нисэхийн салбарын мэргэшсэн экспертүүдээр удирдуулсан багийг Монгол Улсын нэг нисэх буудалд иж бүрэн, цогц үнэлгээ хийлгэх талаар санал солилцсон.

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хүний нөөцийн удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Нэргүй ACI-ийн Ази-Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн Хүний нөөцийн байнгын хорооны хуралдаанд 2024 оны 5 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд оролцсон. Тус хуралдаан нь энэ жил "Байгууллагын соёл" сэдэвтэй зохион байгуулагдсан бөгөөд АНЭУ-ын "Adaptive Global" компанийн Ерөнхий захирал Dr. Enssan Abdallah Байгууллагын соёл-ын талаар Яагаад соёл гэж, байгууллагын соёлын нөлөөллийн талаарх ерөнхий зураглал, соёлын үндэс суурийг тавих, соёлыг тодорхойлох механизм, байгууллагын соёлыг амжилттай өөрчлөх 4 үндсэн тулгуурын талаар илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн ACI Ази, Номхон далай, Ойрх Дорнодын Хүний нөөцийн хорооны 2024 оны зуны хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцсэн:

- Мускет хотноо 2023 оны 11-р сард болсон хурлын протокол батлан
- Бүс нутгийн сөрөгсийн болон ажлын даалгаврын шийгээлт
- ACI World Global Training Update (Issa)
- Залуу удирдах ажилтны шагналыг гэрлүүлэх дараагийн сар
- Дараагийн хурлын тогныг хэлэлцэх

АСI Дэлхийн ерөнхий ассамблей /АСI Ази-Номхон далай, Ойрх Дорнодын бага хурлын үеэр "Ирээдүйн хүний нөөц: Бодит байдлыг өөрчлөх нь" сэдэвт хэлэлцүүлэг 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, ажиллах хүч, ажилтнуудын оролцоо, олон талт байдал болон тэгш байдал нь хөгжиж буй нисэхийн салбарт амин чухал талаар хэлэлцүүлгийн үеэр илтгэгчид онцолж, ажилтнуудын туршлага, сургалтын санаачилга, ирээдүйн бэлэн байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Тус хэлэлцүүлэгт САХУ-ын Эр-Риядын нисэх буудлуудын компанийн хүний нөөцийн захирал-Абдулмажид Алькусайби, Нисэх буудлын үйлчилгээний холбооны ерөнхий захирал-Фабио Гамба, Changi Airports International Pte Ltd-ийн Корпорацын Хүний нөөц хариуцсан дэд захирал Justina Tan, Riyadh Air компанийн Дэд ерөнхийлөгч бөгөөд хүний нөөцийн захирал Нахар М АльЖахани нар илтгэгчээр оролцсон.

Тус Ассамблей дээр АСИ Ази Номхон далай, Ойрх Дорнодын бүсийн "Ногоон нисэх буудлын хөгжлийн хөтөлбөр"-т амжилттай оролцож, итгэмжлэгдсэн тус бүс нутгийн 12 нисэх буудалд шагнал гардуулах үйл ажиллагаа болсон.

6 Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (АСI)-ийн дэлхийн ээлжит Ассамблей Канад Улсын Торонто хотноо, Ази, номхон далай, Ойрх Дорнодын бүсийн ээлжит 2 дугаар Ассамблей бага хурал үзэсгэлэн нь 2025 оны 5 дугаар сард Энэтхэг Улсын Дели хотод зохион байгуулагдана.

### Санал, дүгнэлт

6 • Сошиал медиа платформуудаас ажил мэргэжлийн хамгийн чухал LinkedIn сүлжээний "LinkedIn Learning" нь шинжлэх ухааны үндэслэлтэй, олон талыг хамарсан, баялаг сонирхолтой сургалтуудыг санал болгодог. Уламжлалт сургалтаас дэвшилтэт суралцахуйд чиглэсэн эрс өөрчлөлтийн энэ үед "LinkedIn Learning"-ний сургалтуудад ажилтнуудаа хамруулснаар хүний нөөцийн бодлого, байгууллагын соёлын хүрээнд тэдгээрийг тасралтгүй сургаж хөгжүүлэх, өсөн дэвжих замналыг хангаж, олон талт оролцоог нь дэмжих болно.

• Олон улсын иргэний нисэхийн ICAO, ACI, CANSO зэрэг байгууллагууд нь хурал, семинар, сургалтуудаа бүгд англи хэл дээр зохион байгуулж байгаатай холбоотойгоор ИНЕГ болон ИНУТ-ийн ажилтнуудын эдгээр үйл ажиллагаанд оролцох тэгш байдлыг хангах болон өөрсдийн ажил, мэргэжилтэй холбоотой шинэ мэдээ мэдээллийг олж авах, шилдэг туршлагаас суралцахад зориулан ажилтнуудын англи хэлний түвшинг дээшлүүлэх зорилгоор англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.


• АСИ Ази-Номхон далай, Ойрх Дорнодын бага хурлын Хүний нөөцийн байнгын хорооны хуралдааны үеэр тус бүс нутгийн хүний нөөцийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэхийн тулд хүний нөөцийн ажилтнуудаа солилцон ажиллуулах хөтөлбөр боловсруулахаар тохирсон. Тус хөтөлбөрт хамрагдах ажилтныг эртнээс бэлтгэх шаардлагатай.

удирдлагын багийн манлайлал, зан төлөв, нөлөөлөл, туршлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө, сургалтыг байнга тасралтгүй зохион байгуулах

## Цаашид хийх ажил

- Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/ болон Олон Улсын Нисэх Буудлуудын Зөвлөл /АСИ/-ийн хамтран хэрэгжүүлдэг нисэх буудлын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шилдэг туршлагад нийцсэн, шинэлэг санаачилгыг нисэх буудалд хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагыг бэлтгэдэг Нисэх буудлын удирдлагын мэргэжлийн магадлан итгэмжлэл хөтөлбөр (АМРАР)-т нисэх буудлын удирдах ажилтнууднаас хамруулахын тулд гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллана.
- Саудын Арабын Хаант Улсын “King Khalid Олон улсын нисэх буудал (KKIA)-ын оператор компани болох Riyadh Airports Компани нь “Ирээдүйн нисэхийн удирдах ажилтан хөтөлбөр” /Future Aviation Leaders FAL/ хэрэгжүүлдэг туршлагыг судлан тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судална.
- ИНУТ-ийн ХНУГ-ын хүний нөөцийн ажилтнуудад зориулан 2024 оны 2 дугаар улиралд “Байгууллагын соёл” сэдвээр мэдээллийн цаг зохион байгуулна.

ТАНИЛЦСАН:  
ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН  
ДАРГА

  
Г. БАТБАЯР

ТАНИЛЦСАН:  
ИНУТ-ИЙН ХНХ-ИЙН ДАРГА

  
Б.НЭРГҮЙ